



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ



*АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ*

ЧОЙБАЛСАН ХОТ 2017.03.25

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 8 ДУГААР ЗҮЙЛ: ТӨСВИЙН ЦАГЛАБАР

д/д	Хуулийн заалт	Төсвийн захирагчийн нэрс	Төрийн аудитын байгууллагад ирүүлэх хугацаа	Төрийн аудитын байгууллага дүгнэлтийг гардуулах хугацаа
1	8.9.1	төсвийн шууд захирагч	01-р сарын 25-ны дотор	02-р сарын 25-ны дотор
2	8.9.3	сумын Төрийн сан буюу Засаг дарга	03-р сарын 05-ны дотор	03-р сарын 25-ны дотор
3	8.9.3	аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч	04-р сарын 01-ны дотор	04-р сарын 20-ны дотор
4	8.9.8	төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	02-р сарын 15-ны дотор	03-р сарын 15-ны дотор


САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

- ТӨСВИЙН ХУУЛЬД ЗААСАН БОГИНО ХУГАЦААНД ХЯЗГААРЛАГДМАЛ НӨӨЦӨӨР ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭН ДЭХ ТӨСВИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН, ТӨРИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУДЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛАН, АУДИТЫН ДҮГНЭЛТ ӨГӨХ ШААРДЛАГА ТУЛГАРДАГ.
- ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ДЭЭРХ ШААРДЛАГЫГ ИЛҮҮ ҮР НӨЛӨӨТЭЙ БИЕЛҮҮЛЭХЭД САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫГ УЛСЫН ХЭМЖЭЭНД БОГИНО ХУГАЦААНД НЭГТГЭЖ, УДИРДАХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ ШААРДЛАГА ЗҮЙ ЁСООР УРГАН ГАРСАН.
- САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ ХИЙХ СТАНДАРТЧЛАГДСАН АРГА ЗҮЙГ БОЛОВСРУУЛАХ, ХӨГЖҮҮЛЭХ, АУДИТАД НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫГ “СМАРТ ГРИЙН ТЕХНОЛОГИ” ХХК-ТАЙ ХАМТРАН ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН УДИРДЛАГЫН СИСТЕМ (СТАУС)-ЭЭР АУДИТЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ХИЙН, ХЯНАН, УЛСЫН ХЭМЖЭЭНД НЭГТГЭДЭГ БОЛСОН.

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

- ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ 6 ГАЗРЫН АУДИТЫГ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙН ДҮГНЭЛТИЙГ ӨГӨӨД БАЙНА.
- АУДИТАД ХАМРАГДСАН ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ 4 БАЙГУУЛЛАГУУДАД ЗӨРЧИЛГҮЙ, ДОРНОД БҮСИЙН СУРГАЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭЛЭН ТӨҮГ-Т СӨРӨГ, ЦӨМ СҮРЭГ ҮРЖЛИЙН ТӨВ ТӨҮГ-Т ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ ӨГСӨН.
- НИЙТ 359.7 САЯ ТӨГРӨГИЙН АЛДАА ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛСНЭЭС 157.2 САЯ ТӨГРӨГИЙН АЛДААГ АУДИТЫН ЯВЦАД ЗАЛРУУЛАН, 86.0 САЯ ТӨГРӨГИЙН ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ 3, ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ 1 АЛБАН ШААРДЛАГЫГ ТУС ТУС ХҮРГҮҮЛЭВ.

ЗӨРЧЛИЙГ ГРАФИКААР ХАРУУЛБАЛ:



ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

- ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧДЫН 14 СУМДЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ СТАУС-ЭЭР БАТАЛГААЖУУЛАН, НИЙТ 12,1 САЯ ТӨГРӨГИЙН ӨРТӨГ, 720ХҮН/ЦАГ ЗАРЦУУЛАВ.
- САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР НИЙТ 50,6 САЯ ТӨГРӨГИЙН АЛДАА ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЭН АУДИТЫН ЯВЦАД ЗАЛРУУЛАН, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧДЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ЦАГЛАБАРЫН ДАГУУ ГАРГАН ИРҮҮЛЖ БАЙХ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН АЖИЛЛУУЛАХЫГ 13 СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ ҮҮРЭГ БОЛГОЛОО.

НИЙТ ЗӨРЧЛИЙГ ГРАФИКААР ХАРУУЛБАЛ:



ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИНД...

- МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН 18 ДУГААР ЗҮЙЛИЙН 18.1-Д “ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГУУД ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГАА НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ДАГУУ ГАРГАЖ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР ТОГТООСОН ХУГАЦААНД ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГАД ИРҮҮЛНЭ”

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИНД

- ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 8 ДУГААР ЗҮЙЛИЙН 8.9.8-Д “ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГАА ДАРАА ЖИЛИЙН 02 ДУГААР САРЫН 15-НЫ ДОТОР ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЖ, АУДИТ ХИЙЛГЭСЭН ТАЙЛАНГ 03 ДУГААР САРЫН 15-НЫ ДОТОР ХАРЬЯАЛАГДАХ ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНД ХҮРГҮҮЛЭХ” ГЭЖ ЗААСНЫ ДАГУУ БҮХ ГАЗРУУД ХУУЛИЙН ХУГАЦААНД ИРҮҮЛСЭН.

УДИРДЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

- ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 16.5.6: ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
- НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 18.1: НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРГИЙГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА ХҮЛЭЭНЭ.

НЯГТЛАН БОДОГЧИЙН ҮҮРЭГ

- НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 20.2.8: АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАД НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АСУУДЛААР МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ;
- 20.2.9: АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ХЭРЭГЛЭГЧДИЙГ ЦАГ ХУГАЦААНД НЬ ҮНЭН, ЗӨВ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ;

ДҮГНЭЛТ

- ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮД НЬ ХЯЗГААРЛАЛТТАЙ БОЛОН СӨРӨГ ДҮГНЭЛТ АВЧ БАЙГАА БОЛОН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АЛДАА ЗӨРЧЛИЙН ИХЭНХ ХУВИЙГ БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ ЭЗЭЛЖ БАЙГАА НЬ ДАРААХ ШАЛТГААНТАЙ ХОЛБООТОЙ БАЙНА. ҮҮНД:
 - НЯГТЛАН БОДОГЧ НАР ХУУЛЬД ЗААСАН ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ, УДИРДЛАГЫГ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛЭЭР БҮРЭН ХАНГААГҮЙ
 - БҮТЭЦ ОРОН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭ ТОМИЛГОО
 - УДИРДАХ АЖИЛТНЫ ХУУЛИЙН МЭДЛЭГ ДУТМАГ
 - ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ АЖИЛЛАСАН
 - ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСГЭХ, САНААТАЙ ҮЙЛДЭЛ ГАРГАХ

**АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА БҮХЭНД
БАЯРЛАЛАА.**